**МОНГОЛ УЛС**
**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН**
**ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2023 оны 12 сарын 22 өдөр Дугаар А/695 Есөнбулаг

## Гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалт, Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.1 дэх заалт, "Боловсролын чанарыг сайжруулах" хөтөлбөрийн 3.5.2 дахь заалт, Үнэлгээний хорооны 2023 оны 12 дугаар 12 сарын 15-ны өдрийн 72 дугаар зөвлөмжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Цахим платформыг хэрэгжүүлэх, ашиглалтын зардал" арга хэмжээний хүрээнд аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжигдэх ГААОНӨГ/202311068 дугаартай EYESH.MN платформ ашиглах 600 хэрэглэгчийн эрхийг нийлүүлэх ажлыг "ЕСМ" ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлэх эрхийг Боловсрол, шинжлэх ухааны газар (Ж.Амгаланбаатар)-т олгосугай.

2.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаатай холбогдох хууль, журмын дагуу эрх үүрэг захиалагчийн хяналт, хариуцлагыг гэрээнд тодорхой тусгаж, хэрэгжилтийг тайлагнаж ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны газар (Ж.Амгаланбаатар)-т зөвшөөрсүгэй.

3.Ажлын гүйцэтгэл, чанар, санхүүжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү төрийн сангийн хэлтэс (Х.Баатарзориг), Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ), Нийгмийн бодлогын хэлтэс (С.Мөнхжаргал)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА О.АМГАЛАНБААТАР